

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/145/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББ	Нягтлан бодох бүртгэл



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/180
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ
D 2022/2022 о. / А. БАН В. С. И. Г
19020549

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>42,869,274.37</u>	<u>51,518,695.28</u>
33	АВЛАГА	992,387.37	4,493,696.37
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	3,501,309.00
335	Бусад авлага	992,387.37	992,387.37
3351	Байгууллагаас авах авлага	992,387.37	992,387.37
35	БАРАА МАТЕРИАЛ	41,876,887.00	47,024,998.91
351	Түүхий эд материал	12,112,200.00	13,263,761.91
35110	Тусгай зориулалттай материал	11,771,700.00	13,218,761.91
35130	Эм боох материал	340,500.00	45,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	500,000.00	500,000.00
354	Хангамжийн материал	29,264,687.00	33,261,237.00
35410	Бичиг хэргийн материал	292,250.00	660,050.00
35420	Аж ахуйн материал	11,790,287.00	13,204,287.00
35440	Түлш, шатах тослох материал	795,000.00	1,350,000.00
35450	Барилгын засварын материал	1,000,000.00	00.00
35460	Хүнсний материал	429,150.00	1,251,400.00
35470	Бусад хангамжийн материал	14,958,000.00	16,795,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>773,618,777.70</u>	<u>745,707,955.57</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	773,618,777.70	745,707,955.57
392	Биет хөрөнгө	683,782,777.70	655,871,955.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	581,695,073.15	581,695,073.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	-45,947,118.84	-68,675,678.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,450,000.00	41,450,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,456,250.04	-10,601,250.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	122,336,544.00	133,192,449.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-74,157,849.88	-85,411,164.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,109,133.20	51,974,133.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,249,486.17	-28,865,476.61
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,161,500.00	11,811,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,782,785.67	-1,914,214.23
39217	Ном	27,624,017.95	31,216,583.43
393	Биет бус хөрөнгө	89,836,000.00	89,836,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	89,836,000.00	89,836,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>816,488,052.07</u>	<u>797,226,650.85</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>816,488,052.07</u>	<u>797,226,650.85</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	816,488,052.07	797,226,650.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	449,939,373.00	449,939,373.00
51101	Өмч: - төрийн	449,939,373.00	449,939,373.00
512	Хуримтлагдсан үр дүн	126,868,324.85	107,606,923.63

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	126,868,324.85	126,868,324.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-19,261,401.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	239,680,354.22	239,680,354.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>816,488,052.07</u>	<u>797,226,650.85</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,093,771,032.00	982,101,389.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-10,419,768.00	6,714,927.39
120	Нийтлэг татварын бус орлого	5,371,832.00	6,714,927.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,371,832.00	6,714,927.39
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,371,832.00	6,714,927.39
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-15,791,600.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-15,791,600.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,104,190,800.00	975,386,462.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	134,264,000.00	55,240,862.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,270,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,264,000.00	48,970,862.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,003,300.00	94,290,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,003,300.00	94,290,900.00
1330	Төсвийн захирагчдаас	897,923,500.00	825,854,700.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	897,923,500.00	825,854,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,131,562,917.96	1,001,362,790.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,131,562,917.96	1,001,362,790.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	914,898,327.20	897,294,269.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	702,539,257.72	651,244,624.57
210101	Үндсэн цалин	700,947,129.72	531,753,292.71
210102	Нэмэгдэл	1,592,128.00	119,491,331.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,044,192.15	83,960,695.12
210201	Тэтгэврийн даатгал	59,631,873.92	58,258,632.97
210202	Тэтгэмжийн даатгал	7,015,514.65	6,474,467.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,617,767.76	5,179,574.21
210204	Ажилгүйдлийн даатгал	1,341,408.48	1,267,867.71
210205	Эрүүл мэндийн даатгал	13,437,627.34	12,780,152.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,387,140.00	66,431,307.00
210301	Гэрэл, цахилгаан	2,394,130.00	2,958,857.00
210302	Түлш, халаалт	46,497,000.00	62,930,450.00
210303	Цэвэр, бохир ус	2,496,010.00	542,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,982,723.00	7,267,310.00
210401	Бичиг хэрэг	285,300.00	1,314,250.00
210402	Тээвэр, шатахуун	2,047,423.00	3,216,160.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	734,000.00	372,000.00
210404	Ном, хэвлэл	1,351,950.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	123,600.00	139,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,440,450.00	2,225,800.00

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	15,107,440.00	39,128,740.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	243,500.00	625,350.00
210502	Хоол, хүнс	13,831,040.00	38,503,390.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,032,900.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,996,500.00
210604	Урсгал засвар	00.00	1,996,500.00
2107	Томилолт, зочны зардал	92,000.00	264,900.00
210702	Дотоод албан томилолт	92,000.00	264,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,081,600.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,081,600.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,663,974.33	47,000,192.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,588,000.00	1,233,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,292,650.00	1,892,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,783,324.33	43,874,292.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	216,664,590.76	104,068,521.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	147,576,850.00	46,660,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	100,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,004,650.00	1,534,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	116,278,300.00	30,632,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,725,900.00	13,744,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	468,000.00	750,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	69,087,740.76	57,407,621.31
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,087,740.76	57,407,621.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-37,791,885.96	-19,261,401.22
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,046,950.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,046,950.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,046,950.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-39,838,835.96	-19,261,401.22

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,939,373.00	239,680,354.22	166,707,160.81	856,326,888.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	449,939,373.00	239,680,354.22	166,707,160.81	856,326,888.03
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,593,774.68	11,593,774.68
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,939,373.00	239,680,354.22	126,868,324.85	816,488,052.07
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,939,373.00	239,680,354.22	126,868,324.85	816,488,052.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	449,939,373.00	239,680,354.22	126,868,324.85	816,488,052.07
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-19,261,401.22	-19,261,401.22
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,939,373.00	239,680,354.22	107,606,923.63	797,226,650.85

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,105,747,348.00	969,116,462.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-15,791,600.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-15,791,600.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-15,791,600.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,121,538,948.00	969,116,462.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	151,612,148.00	48,970,862.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	151,612,148.00	48,970,862.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,003,300.00	94,290,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,003,300.00	94,290,900.00
1330	Төсвийн захирагчдаас	897,923,500.00	825,854,700.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	897,923,500.00	825,854,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,091,502,048.00	911,708,840.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,091,502,048.00	911,708,840.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	875,071,107.24	846,157,640.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	698,455,112.86	654,837,124.01
210101	Үндсэн цалин	464,025,945.69	532,728,712.90
210102	Нэмэгдэл	168,845,812.17	114,092,100.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,163,462.00	00.00
210104	Урамшуулал	49,419,893.00	7,925,120.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	91,190.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,169,574.38	83,869,504.68
210201	Тэтгэврийн даатгал	64,487,358.12	58,258,632.97
210202	Тэтгэмжийн даатгал	6,967,083.38	6,474,467.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,373,786.63	5,179,574.21
210204	Ажилгүйдлийн даатгал	1,301,427.61	1,267,867.71
210205	Эрүүл мэндийн даатгал	13,039,918.64	12,688,961.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,960,257.00	69,060,707.00
210301	Гэрэл, цахилгаан	2,394,130.00	2,958,857.00
210302	Түлш, халаалт	49,070,117.00	65,430,940.00
210303	Цэвэр, бохир ус	2,496,010.00	670,910.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,149,000.00	4,830,400.00
210401	Бичиг хэрэг	330,000.00	640,700.00
210402	Тээвэр, шатахуун	789,200.00	750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	799,750.00	750,000.00
210404	Ном, хэвлэл	1,356,400.00	335,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	123,600.00	156,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,750,050.00	2,198,500.00
2105	Нормативт зардал	14,528,340.00	22,669,100.00

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	280,000.00	500,000.00
210502	Хоол, хүнс	13,030,940.00	19,372,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,217,400.00	2,796,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томиллолт, зочны зардал	92,000.00	264,900.00
210702	Дотоод албан томиллолт	92,000.00	264,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,081,600.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,081,600.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,635,223.00	9,625,905.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,250,000.00	1,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,385,223.00	8,225,905.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	216,430,940.76	65,551,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	147,343,200.00	65,551,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,433,000.00	20,257,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	116,278,300.00	30,632,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,725,900.00	13,744,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	906,000.00	917,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,722,549.76	33,177,271.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,722,549.76	33,177,271.31
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,365,191.00	24,230,350.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,365,191.00	24,230,350.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>14,245,300.00</u>	<u>57,407,621.31</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,245,300.00	5,443,105.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,245,300.00	5,443,105.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,245,300.00	5,443,105.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,245,300.00	5,443,105.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-14,245,300.00</u>	<u>-5,443,105.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	920,145,600.0	862,738,135.7	57,407,464.3	93.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	920,145,600.0	862,738,135.7	57,407,464.3	93.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	898,967,800.0	841,563,835.7	57,403,964.3	93.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	680,060,000.0	654,837,124.0	25,222,876.0	96.3
210101	Үндсэн цалин	450,272,400.0	532,728,712.9	(82,456,312.9)	118.3
210102	Нэмэгдэл	162,494,500.0	114,092,100.7	48,402,399.3	70.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,988,000.0	-	20,988,000.0	-
210104	Урамшуулал	46,305,100.0	7,925,120.0	38,379,980.0	17.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,808,100.0	83,869,504.7	7,938,595.3	91.4
210201	Тэтгэврийн даатгал	64,605,800.0	58,258,633.0	6,347,167.0	90.2
210202	Тэтгэмжийн даатгал	6,800,600.0	6,474,467.8	326,132.2	95.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,440,500.0	5,179,574.2	260,925.8	5.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,360,100.0	1,267,867.7	92,232.3	93.2
210205	Эрүүл мэндийн даатгал	13,601,100.0	12,688,962.0	912,138.0	93.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,290,900.0	69,060,707.0	24,230,193.0	74.0
210301	Гэрэл, цахилгаан	4,929,800.0	2,958,857.0	1,970,943.0	60.0
210302	Түлш, халаалт	83,692,400.0	65,430,940.0	18,261,460.0	78.2
210303	Цэвэр, бохир ус	4,668,700.0	670,910.0	3,997,790.0	14.4
2104	Хангамж, бараа материалын зардал	4,545,000.0	4,536,500.0	8,500.0	99.8
210401	Бичиг хэрэг	350,000.0	346,800.0	3,200.0	99.1
210402	Тээвэр, шатахуун	750,000.0	750,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.0	750,000.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	335,000.0	335,000.0	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.0	156,200.0	3,800.0	97.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,200,000.0	2,198,500.0	1,500.0	99.9
2105	Нормативт зардал	22,672,900.0	22,669,100.0	3,800.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.0	500,000.0	-	100.0
210502	Хоол, хүнс	19,372,900.0	19,372,900.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,800,000.0	2,796,200.0	3,800.0	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	264,900.0	264,900.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	264,900.0	264,900.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний			-	

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	бусад зардал	5,326,000.0	5,326,000.0		100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.0	1,400,000.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,926,000.0	3,926,000.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,177,800.0	21,174,300.0	3,500.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,177,800.0	21,174,300.0	3,500.0	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,257,300.0	20,257,300.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,500.0	917,000.0	3,500.0	99.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	920,145,600.0	920,145,600.0	-	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	825,854,700.0	825,854,700.0	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	825,854,700.0	825,854,700.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	94,290,900.0	94,290,900.0	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	94,290,900.0	94,290,900.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	52.0	52.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	37.0	37.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	14.0	14.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,970,705.00	48,970,705.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,970,705.00	48,970,705.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,593,805.00	4,593,805.00
2104	Хангамж, бараа материалын зардал	293,900.00	293,900.00
210401	Бичиг хэрэг	293,900.00	293,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,299,905.00	4,299,905.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,299,905.00	4,299,905.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,376,900.00	44,376,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,376,900.00	44,376,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,632,200.00	30,632,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,744,700.00	13,744,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,970,800.00	48,970,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,970,800.00	48,970,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,970,800.00	48,970,800.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэх, анхан шатны баримтад үндэслэн холбогдох тайлан мэдээг үнэн зөв бэлтгэн тайлагнаж байх, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь сургалтын сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд бага дунд боловсролын багш бүр хичээл, сургалтын бэлтгэлийг чанартай ханган, үр дүнтэй зохион байгуулж, багш, хүүхэд, эцэг эх асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхэд бүрийн хөгжил, төлөвшил, сурлагын чанар ахиц гаргахыг зорилгоо болгон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэн, улирал бүр тайлагнаж ажилласан.

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны төлөвлөгөөний дагуу 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 920,145.6 мянга төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,802.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,351.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 920,145.6 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 48,970.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 969,116.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 10,855.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 865.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 3,592.6 мянган төгрөгийн ном, 650.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, нийт 15,963.5 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 5,443.1 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 10,520.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 2,394.6 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 52,961.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 50,208.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 4,493.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Энэ нь тайлант онд аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж, шалгалтаар ажиллагсадтай холбоотой төлбөрийн акт тавигдаж, үүний үлдэгдэл 3,501.3 мянган төгрөгийг ажиллагсадтай холбоотой авлагаар бүртгэн тайлагнасан байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 47,025.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 745,708.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	992.4	4,493.7	3,501.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	41,876.9	47,025.0	5,148.1
Үндсэн хөрөнгө	773,618.8	745,708.0	(27,910.8)
Нийт хөрөнгө	816,488.1	797,226.7	(19,261.4)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	816,488.1	797,226.7	(19,261.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	816,488.1	797,226.7	(19,261.4)

Бараа материалын дансны үлдэгдэл 47,025.0 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 5,148.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 745,708.0 мянган төгрөг болж 27,910.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онын хөрөнгийн элэгдлээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 797,226.7 мянган төгрөг болж 19,261.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 920,145.6 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 920,145.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвөөс 920,145.6 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 862,738.1 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 57,407.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 862,738.1 мянган төгрөг буюу 93.8 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 48,970.7 мянган төгрөг төвлөрч, урсгал шилжүүлэгт 44,376.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 4,593.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 10,855.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 865.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 3,592.6 мянган төгрөгийн ном, 650.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, нийт 15,963.5 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 5,443.1 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 10,520.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Тайлант хугацааны худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 7 харилцагч байгууллагатай хийсэн 8,555.8 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулаагүйг завсрын аудитаар илрүүлж, зөрчлийг арилган ажилласан.

3.8 Аудитын гол асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 46 нэр төрлийн 40,340.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 1 нэр төрлийн 200.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө, бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 6 нэр төрлийн 1,353.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил тус тус бүртгэлтэй, тайлант хугацаанд 4 албан хаагчийн 3,223.1 мянган төгрөгийн цалин хөлсийг НДШ төлөлтийн тайланд дутуу тайлагнасан, цалингаас бусад

5,000.0 мянган төгрөгөөс дээш 5 удаагийн 56,429.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 111 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 34 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй, цалингаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш 5 удаагийн нийт 56,429.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 286.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 693,239.7 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дах Төрийн аудитын газар болон “Ихмонгол Хөлөг Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 1 алдаа зөрчил давтан гарч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 128,354.9 мянган төгрөгийн 12 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 24,359.1 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 2,448.8 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 101,547.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 24,359.1 мянган төгрөгийн 3 алдааг залруулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцооллыг шалгахад тайлант хугацаанд хөрөнгийн ашиглах хугацааг "-1" болон "0" гэж санхүүгийн программд тохируулснаас 28 нэр төрлийн 16,463.3 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийг ашигласан хугацааны туршид тооцоогүй нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", УСНББОУС 17-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Тайлант хугацаанд үнэ төлбөргүй хүлээн авсан 3 нэр төрлийн 7,895.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн элэгдлийг ашигласан хугацааны туршид байгуулаагүй нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", УСНББОУС 17-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудитлагдсан тайлантай тулгахад санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тасалбар болголт", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 2,448.8 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тус байгууллагад ажилладаггүй, батлагдсан орон тоонд байхгүй 2 хүнд 1,621.9 мянган төгрөгийн, Захирлын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Б/04 дугаар тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн 1 хүнд 523.4 мянган төгрөгийн, нийт 2,165.3 мянган төгрөгийн цалин тооцон олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр

ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн илүү олгосон цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант хугацаанд 2 албан хаагчид удирдлагын гаргасан Үр дүнгийн урамшуулалт цалин олгох тушаалаар баталсан хувийг нэмэгдүүлэн нийт 119.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин илүү олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн илүү олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 2021 оны 12 дугаар сард 163.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4-д “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн сахилгын шийтгэлтэй албан хаагчид олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 111 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 34 мэдээллийг хугацаа хоцроосон, 1 мэдээллийг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 46 нэр төрлийн 40,340.8 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 6 нэр төрлийн 1,353.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоолын 1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийн анги доторхи зүйлийг НББОУС-д нийцүүлэн зөв ангилан бүртгэх, буруу бүртгэснийг данс хооронд шилжүүлэх замаар залруулан бүртгэхийг дарга, захирал нарт даалгасугай" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө материалыг зөв ангилан бүртгэж тайлагнаж байх

3. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 1 нэр төрлийн 200.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет бус хөрөнгийг шийдвэрлэх

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 4 албан хаагчийн 3,223.1 мянган төгрөгийн цалин хөлсийг НДШ төлөлтийн тайланд дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж,

тогтоосон хугацаанд төлөх” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг үндэслэн холбогдох тайлан мэдээг үнэн зөв бэлтгэн тайлагнаж байх

5. Шилэн данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Цалингаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш 5 удаагийн 56,429.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургууль	12	128,354.9	3	24,359.1	3	2,448.8	1	-	5	101,547.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn